

**МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ 2018 ОНЫ
“ХӨВГҮҮДИЙН 16 ХҮРТЭЛ
НАСНЫ ФУТЗАЛЫН УАШТ”-ИЙ ЗААВАР**

2017.12.01

Нэг. Тэмцээний зорилго

- 1.1 Клубүүдийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хүргэх.
- 1.2 Тэмцээний бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт хүргэх.

Хоёр. Тэмцээний удирдлага, зохион байгуулалт, хугацаа

- 2.1 Тэмцээнийг МХБХ-ноос томилогдсон Тэмцээн зохион байгуулах комисс/ТЗБК/ удирдан, Монголын хөлбөмбөгийн холбоо /МХБХ/-ны дүрэм, журмуудыг болон бусад эрх зүйн бичиг баримтуудыг мөрдөж зохион байгуулна.
- 2.2 МХБХ-ны “Хөвгүүдийн 16 хүртэл насны ФУАШТ” /цаашид Тэмцээн/ МХБХ-ны Футзалын ордонд **2018 оны 01 сарын 05 - 15**-ны хооронд зохион байгуулагдана.
- 2.3 Тэмцээнд зөвхөн мэдүүлэгт тусгагдсан дасгалжуулагч, тоглогч нар оролцоно.
- 2.4 Шүүгчийн шийдвэр эцсийн байх зарчим ямагт үйлчилнэ.

Гурав. Бүртгэл, шилжилт хөдөлгөөн

- 3.1 Монгол улсын иргэн мэдүүлэгт бүртгүүлэхдээ дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:
 - а) Багууд тоглогчдын төрсний гэрчилгээ, сурагчийн үнэмлэхийг ТЗБК-д бүртгүүлж баталгаажуулна.
 - б) Тэмцээнд оролцох клубын албан ёсны мэдүүлэгт **14 /2 хаалгач/ тамирчин, 2 албаны хүн** байх ба ахлах дасгалжуулагч заавал багтсан байна.
- 3.2 Багийн мэдүүлгийг МХБХ-ны тэмцээний зааварт заасан хугацаанд, шаардлагын хэмжээнд бүрэн бүрдүүлсэн нөхцөлд, тухайн баг тэмцээний сугалаанд оролцох эрхтэй болно.
Хавсралт 2. МХБХ-ны Футзалын тэмцээний мэдүүлгийн хуудас
- 3.3 Клуб, багууд тухайн тэмцээнд оролцох үндсэн ба туслах хувцасны өнгийг ирүүлнэ.
Хавсралт 3. Хувцасны өнгө
- 3.4 Тоглогчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан бичгийг мэдүүлэгтэй хамт хавсаргаж ирүүлнэ.
Хавсралт 4. Эрүүл мэндийн үзлэгийн хуудас
- 3.5 Дараах шаардлагуудыг хангаагүй мэдүүлгийг бүртгэж авахгүй. Үүнд:
 - 1) Зураг /сүүлийн 6 сард авахуулсан/ дутуу болон шаардлага хангаагүй
 - 2) Мэдүүлэг баталгаат гарын үсэггүй
 - 3) Хувийн дугааргүй
 - 4) Регистрийн дугааргүй
 - 5) Овог, нэр дутуу
 - 6) ТЗБЖ-ын Хавсралт 2 бүрдүүлээгүй
 - 7) ТЗБЖ-ын Хавсралт 3 бүрдүүлээгүй
 - 8) Тухайн багийн харьцах цахим хаяггүй
- 3.6 Клуб, багууд тэмцээний мэдүүлгийг үнэн зөв бөглөж зөрчил гарсан тохиолдолд тухайн клуб, баг бүрэн хариуцна. Клуб, багууд тэмцээнд оролцох эрхгүй тоглогчийг тоглолтонд оруулсан тохиолдолд тухайн клуб, багийг тэмцээнээс хасч өмнөх тоглолтуудын оноо, бөмбөгний тоог хүчингүйд тооцно. Мөнгөн торгуулийг давхар ноогдуулна.
- 3.7 Тоглогчдын бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдолтой бусад асуудлуудыг МХБХ-ны зохих журмын дагуу явагдана. Аливаа шилжилт хөдөлгөөнийг зөвхөн “МХБХ-ны Тоглогчдын шилжилт хөдөлгөөний журам”-ын дагуу үйлдсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 3.8 Тэмцээнд оролцох багуудын мэдүүлгийг **2017 оны 12-р сарын 22-ны өдөр** хүртэл хүлээн авна. Багууд мэдүүлгээ ТЗБК-т эх хувиар нь авчирч өгөх ба дараах цахим хаягаар хүлээн авна.

Дөрөв. Техникийн зөвлөлгөөн, тэмцээний сугалаа ба нээлт

4.1 Техникийн зөвлөлгөөнд клубийн ахлах дасгалжуулагч заавал оролцох шаардлагатай. Тэмцээнтэй холбогдолтой бүх мэдээлэлийг тус зөвлөгөөнд ТЗБК-оос өгөх тул дараа нь тэмцээний үеэр тэмцээн зохион байгуулалттай холбоотой асуудал гарвал хүлээж авахгүй болно. Мөнгөн торгуулиа барагдуулаагүй багуудыг тэмцээнд оролцуулахгүй.

2017 оны 01-р сарын 04-ны өдрийн 12.00 цагт МХБХ-ны сургалтын танхимд явагдана. Техникийн зөвлөлгөөнд ахлах дасгалжуулагч, багийн менежер нар заавал оролцох шаардлагатай.

4.2 Техникийн зөвлөлгөөнд клубүүд тоглолтын болон хаалгачийн 2 ээлжийн хувцасыг авчирна. Багууд эзэн баг болон зочин багийн өмсгөлүүдээ эцэслэн шийдвэрлэсэн байна. Багуудын хувцас хэрэглэлтэй холбогдолтой бүх асуудлуудыг МХБХ-ны “Тоглогчдын хувцас хэрэглэлийн журам”-ын дагуу ТЗБК шийдвэрлэнэ.

/Журамд заасан газруудаас өөр хувцас хэрэглэл дээр ивээн тэтгэгч байгууллагуудын логог хадаж болно./

4.3 Футзалын тэмцээнд оролцох тоглогчид дүрмийн дагуу шаардлага хангасан өнгө, будаг гардаггүй, товруугүй ултай заалны зориулалтын пүүзтэй байна. Мөн 5 дах тоглогчийн өмсгөлийг зохих шаардлагын дагуу бэлдсэн байна. Өөр төрлийн пүүзтэй тохиолдолд тоглолтонд оролцуулахгүй.

Тав. Тэмцээний журам

5.1 Тэмцээний бүх үйл ажиллагаа “Тэмцээн зохион байгуулах журам”-ын дагуу явагдана.

5.2 Тэмцээний шилдэг 8 багийг МХБХ-ны “Хөвгүүдийн 16 хүртэл насны лиг” –ийн тэмцээнд оролцуулна.

5.3 Баг болгон 2 ээлжийн өөр өнгөтэй хувцастай байна. Хувцас хэрэглэлтэй холбогдолтой аливаа асуудлыг МХБХ-ны “Тоглолтын хувцас хэрэглэлийн стандартын журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

5.4 Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаа болон тухайн тэмцээний зохион байгуулалттай холбоотойгоор зарласан албан ёсны арга хэмжээнүүдэд аль нэг баг оролцоогүй эсвэл бүрэн бус бүрэлдэхүүнтэй оролцсон бол тухайн багт торгууль ноогдуулна. Энэ тухай албан мэдэгдлээр шаардсан хугацаанд ноогдуулсан төлбөрийг хийгээгүй бол тус тэмцээнд болон дараагийн тэмцээнд оролцуулахгүй.

5.4 Тоглолт эхлэхэд багийн хүний тоо дүрэмд заасан хэмжээнд бүрдээгүй, тэмцээн хаяж явсан тохиолдолд тухайн багийн өмнөх тоглолтуудын дүнг хүчингүй болгож, тухайн тэмцээнээс хасна.

5.5 Тоглолтын протоколыг тогтоосон хугацаанд бөглөж ирүүлээгүй улмаас тоглолт эхлэх хугацааг хойшлуулсан багт сахилгын арга хэмжээ авна

5.6 Багийн мэдүүлэгт 0 дугаартай тамирчин мэдүүлэхгүй бөгөөд тамирчин тухайн тэмцээний бүх тоглолтонд оролцохдоо зөвхөн мэдүүлэгт бичигдсэн хувийн дугаартай хувцас өмсөнө. Зөрчил гарсан тохиолдолд тоглогчийг тоглолтонд оролцуулахгүй.

5.7 Тоглолт эхлэхийн өмнө өрсөлдөгч хоёр баг “Fair Play” зарчмыг баримталж тоглохоо илэрхийлэн гар барих ёслолыг заавал үйлддэгтэй нэгэн адил тоглолт дуусмагц тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тамирчид шүүгч нартай болон өөр хоорондоо гар барих үүрэгтэй.

5.8 Тухайн тоглолтын эхлэл, төгсгөлд хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлнэ.

5.9 Тэмцээнд тамирчдын хувцас солих өрөөнд багийн мэдүүлэгт бичигдээгүй хүн орохыг хориглоно.

Зургаа. Сахилга бат, ёс зүйн журам

6.1 МХБХ-ноос зохион байгуулж байгаа тэмцээний тоглолтын үеэр аливаа маргаан, ёс зүйн зөрчил, сахилга батын асуудлуудыг МХБХ-ны “Сахилга батын хорооны дүрэм” болон “Ёс зүйн хорооны дүрэм”-ээр зохицуулна.

Долоо. Шагнал, урамшуулал

7.1 Тэмцээний эхний 3 байр эзэлсэн багт Өргөмжлөл, медаль, түрүүлсэн багт “Шилжин явах Цом” олгоно.

1-р байрын шагнал: Шилжин явах цом, алтан медаль, батламж, 1,000,000 төгрөг

2-р байрын шагнал: Мөнгөн медаль, батламж, 800,000 төгрөг

3-р байрны шагнал: Хүрэл медаль, батламж, 600,000 төгрөг

7.2 Тэмцээний шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна. Үүнд:

Шилдэг хаалгач: цом, батламж, 50,000 төгрөг

Шилдэг тэгш тоглогч: цом, батламж, 50,000 төгрөг

Шилдэг довтлогч: цом, батламж, 50,000 төгрөг

Найм. Бусад асуудал

8.1 Энэ зааварт тусгагдаагүй бусад асуудлыг ТЗБК-оос тухай бүрт нь шийдвэрлэнэ.